


СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
2021 ОНЫ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ, ЭМЧ ЭМНЭЛГИЙН АЖИЛЧДААС
АВСАН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2021 оны 11 дүгээр сарын 24

Улаанбаатар

Үйлчлүүлэгчдээс авсан сэтгэл ханамжийн үнэлгээ, үнэлгээний дагуу авсан арга хэмжээнүүд

2021 оны эхний 3 улирлын байдлаар 276 үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгаа авсан байна. Эерэг сэтгэл ханамж 76,7%-тай байна.



2021 оны 1-р улиралд-73,4%

2021 оны 2-р улиралд-76,1%

2021 оны 3-р улиралд-80.6%

Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь 2021 оны 1,2,3-р улирлын дүнг харьцуулахад оны эхний 1-р улирлаас 7.2-р% өссөн үзүүлэлттэй байна.

“Байгууллагын соёл” чиглэлээр хийсэн ажлууд:

- Шинэ эмнэлгийн байранд Поликлиник тасгийг нүүлгэн шилжүүлж үйлчлүүлэгчийг угтах, бүртгэх, лавлах, хөтөчийн үйл ажиллагаа болон мэдээлэлийн самбарыг байршуулан зохион байгуулсан.
- Тусламж үйлчилгээний хүлээгдэл, үзлэгийн цагийн дараалал ихтэй холбоотой гомдлын дагуу цаг захиалах дугаарын ачааллыг багасгах зорилгоор нэмэлтээр 2 утас ажиллуулсан.
- Цахим ажилтанг 1-ээр нэмэгдүүлэн 3 болгосон.
- Үйлчлүүлэгчдийн дарааллыг зохицуулах зорилгоор дугаар дуудах машиныг суурьлуулсан.
- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэг цэгийн үйлчилгээнд эх баригч мэргэжилтэй хөтөч сувилагчийг ажиллуулж жирэмсэн эмэгтэйчүүдийн мэдээлэл сургалтын асуудлыг шийдвэрлэж ажиллаж байна.
- Жирэмсэн эхэд үзүүлэх тусламж үйлчилгээний хүлээгдэлийг бууруулах зорилгоор эмэгтэйчүүдийн эмчийн орон тоог 1 эмчээр нэмэгдүүлсэн



- Байгууллагын гадна талбайд 120 машины зогсоолыг ашиглалтанд оруулж ажилчид болон үйлчлүүлэгчдийн машины зогсоолын асуудлыг бүрэн шийдвэрлэсэн.





- Хуучин эмнэлгийн хойд хэсэгт борооны ус тогтож явган болон тэргэнцэртэй хүн явахад хүндрэлтэй байсныг засаж сайжруулсан зам тавьж, явган хүний замыг эко хавтангаар хийсэн.



“Тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал” чиглэлээр :

- Дотрын өдрийн эмчилгээний тасаг
- Мэс заслын өдрийн эмчилгээний тасаг
- Сэргээн засах өдрийн эмчилгээний тасаг
- Гемодиализийн тасаг
- Зүрх судасны кабинет
- Уушигны кабинет
- Хавдарын кабинетыг шинээр нээж ажиллуулсан.
Мөн тусламж үйлчилгээ, оношлогоо үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр
- Зүрхний өнгөт эхо
- Дурангын эмч
- Зүрхний ачаалалтай цахилгаан бичлэг
- Тархины цахилгаан бичлэг
- Тархины судасны бичлэг
- Ходоодны дурангын оношлогоо
- Хавдрын эсийг өндөр давтамжийн радио долгионоор түлэх эмчилгээ
- Жирэмсний хяналтын нэг цэгийн үйлчилгээний төвийг эмнэлгийн хуучин байранд төвлөрүүлэн эмэгтэйчүүдийн эмчийн орон тоог нэмэгдүүлж, эмэгтэйчүүдийн үтрээний эхо, ургийн эхо, ургийн зүрхний цохилтыг хэмжих , мөн жирэмсэн эмэгтэйчүүдийн сургалтын танхимын засвар үйлчилгээний ажлыг эхлүүлэн, дараагын улиралд шинээр өсвөр үеийн кабинетыг нээж эмч сургахаар төлөвлөн ажиллаж байна.





- Ковидын халдварын эсрэг дархлаа тогтоох дархлаажуулалтанд ард иргэд, байгууллага, аж ахуйн ажилчид нийт 41573 хүнийг дархлаажуулсан. Үүнээс 1-р тун 19812 хүн, 2-р тун 10677 хүн, 3-р тун 11084 хүнийг дархлаажуулсан байна.



- Ковидын халдварыг тусгаарлан эмчлэх эмнэлгийг 200 ортойгоор зохион байгуулж 2021 оны 03 сарын 17-ноос эхлэн эмнэлзүйн 14 хүний бүрэлдхүүнтэй 6 баг ажиллаж байна.
Эмнэлзүйн багуудыг тусгаарлах эмнэлэгт орох бүрт халдвар хамгааллын дэглэм баримтлах тал дээр сургалт явуулж хяналт хийж, эмчилгээ оношлогоо, сувилахуйн тусламж үйлчилгээний мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна..

